

# МАЛ АЖ АХУЙ

## Танилцуулага

2015

Мал аж ахуйн салбар нь хүн амыг хүнсээр, боловсруулах үйлдвэрүүдийг түүхий эдээр хангах үндсэн эх булаг байсаар ирсэн одоо ч энэ ач холбогдлоо алдаагүй байна. Өөрөөр хэлбэл мал аж ахуйн хөгжлөөс манай орны эдийн засаг ихээхэн хамааралтай хэвээр байна. Иймд мал аж ахуйгаа анхаарч, байгаль цаг уураас хараат байдлыг багасгаж, өгөөж үр ашгийг нь дээшлүүлэх нь чухал байна.

Энэ салбараас хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүний 80 орчим хувийг үйлдвэрлэж, экспортын нийт орлогын 10 шахам хувийг бүрдүүлж байна. Улсын нийт хүн амын гуравны нэг нь зөвхөн мал аж ахуйн орлогоор амьдардаг бөгөөд бүх хүн амыг шууд бус байдлаар



## Монгол улсын малын тоо/мян.толгой/

Малын төрөл	2000	2005	2009	2010	2011	2012	2013	2014
Тэмээ	322.9	254.2	277.1	269.6	280.1	305.8	321.0	349.3
Адуу	2660.7	2029.1	2221.3	1920.3	2112.9	2230.4	2616.2	2995.2
Үхэр	3097.6	1963.6	2599.3	2176.0	2339.7	2584.6	2905.3	3412.8
Хонь	13876.4	12884.5	19274.7	14480.4	15668.5	18141.4	20036.6	23209.5
Ямаа	10269.5	13267.4	19651.5	13883.2	15934.6	17558.7	19196.7	22003.6
Бүгд	30227.5	30398.8	44023.9	32729.5	36335.8	40920.9	45075.7	51970.4

Мал аж ахуйн салбараас жилд дунджаар хонины ноос 27.5 мян тн, ямааны ноолуур 6.5 мян тн, бодын хөөвөр 1.3 мян тн, тэмээний ноос 1.7 мян тн –ыг бэлтгэж, 400.0 орчим сая литр сүү үйлдвэрлэдэг.

## Экспортын гол нэрийн бараа /2014 оны байдлаар

Гол нэр төрлийн бараа	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
Адууны мах	тонн	1822.2
Малын дайвар бүтээгдэхүүн	тонн	202.8
Богийн өлөн гэдэс	тонн	339.6
Адууны дэл сүүл	тонн	606.0
Үхэр адууны шийр	сая дм <sup>2</sup>	57.3
Хонь, хурганы боловсруулсан арьс	сая дм <sup>2</sup>	108.7
Ямаа, ишигний боловсруулсан арьс	сая дм <sup>2</sup>	131.4
Ноолуур	тонн	4672.0

## Яагаад монгол, давуу тал

- Дэлхийн хоёр том зах зээлийн дунд орших газар зүйн өвөрмөц байршил
- Дэлхийд малыг анх гаршуулж, гэршүүлсэн голомтуудын нэг
- Ардын сонгон үржүүлгийн үр дүнд байгаль-цаг уурын хатуу ширүүн нөхцөлд дасан зохицож, биологийн онцгой шинжийг хадгалсан монгол мал
- Монгол улсын нийт ажиллагсдын 35 орчим хувь тухайн салбарт ажиллаж хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалтын орлогоор амьжиргааныхаа үндсэн эх булгийг бүрдүүлж байдаг.
- Монгол үүлдрийн мал нь жилийн дөрвөн улиралд бэлчээрийн маллагаанд байж, үржин төлжиж ашиг шимээ өгсөөр ирсэн уламжлалтай билээ.
- Малын тоо тогтмол өссөөр байна.

## Боломжууд

- Дагалдах бүтээгдэхүүн ашиглаж их ашиг олох боломжтой.
- Түүхий эдийг боловсруулж эцсийн бүтээгдэхүүн болгосон тохиолдолд орлогын хэмжээ доод тал нь 3 дахин нэмэгдэх боломж.
- Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн технологийг боловсронгуй болгож гадаад, дотоодын зах зээлд өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэх.
- Амьтны шалгарсан удмыг сайжруулагчаар ашиглах, биотехнологи, генийн инженерчлэлийн дэвшилт аргыг нэвтрүүлэх замаар малын үүлдэрлэг байдлыг сайжруулах;
- Мал эмнэлгийн олон улсын байгууллагуудтай бүх талын хамтын ажиллагаа үүсгэх

## Төрөөс мал аж ахуйн талаар баримтлах бодлого

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний 80 гаруй хувийг үйлдвэрлэж, хүн амаа хүнс, өргөн хэрэглээний бараагаар хангах эх үүсвэр болж байгаа бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг бүсчлэн хөгжүүлж, дотоод зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн чанар сайтай, аюулгүй түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлэх, экспортын нөөцийг нэмэгдүүлэхэд мал аж ахуйн бодлого чиглэгдэнэ.

## Эрчимжсэн мал аж ахуй



Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр нь Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн газар тариалан, эрчимжсэн МАА-г зохистой хослуулан хөгжүүлэх хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, импортыг бууруулах зорилготой.

Эрчимжсэн фермерийн аж ахуй. Хот суурин газрын хүн амыг аюулгүй хүнс тэжээлээр хангах хэрэгцээ шаардлагын улмаас эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх талаар төр засгаас ихээхэн анхаарч байгаа билээ. Үүнтэй холбоотойгоор сүүлийн

жилүүдэд эрчимжсэн фермерийн аж ахуйн тоо нэлээд нэмэгдэж, энэ чиглэлийн бизнес эрхлэгчдийн тоо нэмэгдсээр байна.

### Холбоо барих

Баттөгс Анужин  
Сурталчилгаа, зөвлөх үйлчилгээний  
мэргэжилтэн  
Хөрөнгө Оруулалтын Газар  
15141 ЗГ-ын XI байр, Самбуугийн гудамж-11,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар, Монгол Улс  
Утас: 976-11320706  
Факс: 976-324076  
Цахим хаяг: [anujin@investmongolia.com](mailto:anujin@investmongolia.com)

### Ашигтай холбоосууд

Хүнс, Хөдөө Аж Ахуйн яам  
<http://www.mofa.gov.mn/new/>  
Монголын Хөдөө Аж ахуйн Үндэсний  
Ассоциаци  
Нийслэлийн Хөдөө Аж Ахуйн Ассоциаци  
Мал, Тариалангийн Эрсдэл Судлах Төв ТББ